

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Хөдөө аж ахуйн бирж “ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/171/СТА-ТӨҮГ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАК	Хувийн аудитын компани
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	9
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	15
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	17



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Х.БААТАР ТАНАА

2019.03.15 № 06/445
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөдөө аж ауйн бирж” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Хөдөө аж ауйн бирж” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн.

Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хөдөө аж ауйн бирж” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Хөдөө аж ауйн бирж” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Баатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 28-наас 3 дугаар сарын 12–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 14-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын

удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Пийк ОМ Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг “Пийк ОМ Аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн ерөнхий мэдээллийг аудитын төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих оновчтой тогтолцоог бий болгох замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

САГ-2019/171/СТА-ТӨҮГ

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-д тус компанийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Биржийн арилжааг зохион байгуулах;
2. Биржийн байнгын гишүүн оролцогчид суудлын эрх олгох;
3. Биржийн байнгын бус гишүүн оролцогчид биржийн арилжаанд оролцох зөвшөөрөл олгох;
4. Биржийн арилжааны явцад зохиомлоор үнэ өсгөх, бууруулах оролдлого хийж байгаа эсэхэд хяналт тавих, таслан зогсоох;
5. Нэг хэлцлээр арилжих бараа, түүхий эдийн доод хэмжээг тогтоох;
6. Стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна. Үүнд:

- 2017 онд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын дагуу холбогдох өөрчлөлтийг тусгаагүй,

- НББОУС-2-ын 6 (а,б,в)-д заасан тодорхойлолттой нийцээгүй,
- Дансны нэгдсэн төлөвлөгөө нь програмын дансны кодчлолоос зөрүүтэй байна.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ИМРАСТ” програм хангамж ашигладаг байна.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Энэ нь нийт зардлын хэмжээ бүтээгдэхүүний өртгийг бүрдүүлж компанийн ашиг алдагдлыг тодорхойлдогтой холбоотой юм.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны нийт зардал 1,693.2 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 16.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 гэж тооцсон нь эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

САГ-2019/171/СТА-ТӨҮГ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Арилжааны банкинд хугацаатай хадгалуулсан 201.0 сая төгрөгийн хүү 2.8 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй нь 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, мөн хуулийн 14.4.2-т “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага*”-ыг *нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамж, шатахуун, сэлбэг хэрэгсэл, цэвэрлэгээ үйлчилгээ зэрэг 162.1 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.*” Гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Тус компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар 1.2 сая төгрөгийн авлагыг данснаас хасч найдваргүй авлагын зардлаар бүртгэсэн нь Санхүү эдийн засгийн сайд /хуучнаар/-ын 2000 оны 116 дугаар тушаалын хавсралт 1-ийн 3 дугаар зүйлийн 3.4.1 (д)-дэх “*Дт Найдваргүй авлагын зардал, Кт Найдваргүй авлагын хасагдуулга*” гэсэн заалттай нийцээгүй байна.
- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 7.9 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд, 5.7 сая төгрөгийн үнэ бүхий автомашины дугуйг багаж хэрэгслийн дансанд бүртгэсэн нь НББОУС-16-д “*Үндсэн хөрөнгө гэж үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа, нэгээс дээш тайлангийн хугацаанд ашиглагдах биет зүйлсийг хэлнэ*”, Санхүү эдийн засгийн

сайд /хуучнаар/-ын 2000 оны 116 дугаар тушаалаар баталсан “Дансны жагсаалтын үлгэрчилсэн загвар”-ыг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж	4	7,5	
	Дүн	4	7,5	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд анхаарал татахуйц бусад асуудал гараагүй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

ТӨБЗГ-ын 2017 оны 649 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК –ийн 2018 оны зорилтот түвшинг тодорхойлж үйл ажиллагааны орлогыг 1,821.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,306.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 61.0 хувиар давуулан биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтэнд үндсэн бус үйл ажиллагааны орлого нөлөөлжээ.

Тайлант онд үйл ажиллагааны зардлыг 1,595.8 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 1,693.2 сая төгрөгийн зардал гарсан байна. Зардал 97.5 сая төгрөгөөр хэтэрсэн нь хувьчлалтай холбоотой гарсан зардал нөлөөлсөн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр ил тод мэдээлж ажилласан байна. Үүнд:

- ТӨБЗГ-ын 2017 оны 649 дугаар тогтоолоор баталсан 1,821.6 сая төгрөгийн орлогын , зарлагын 1,595.2 сая төгрөгийн, худалдан авах ажиллагааны 47.9 сая төгрөгийн төлөвлөгөө,
- 2017 оны санхүүгийн тайлан,
- Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 434.0 сая төгрөгийн мэдээлэл,
- ТУЗ-ийн 2018 оны 4 дүгээр тогтоолын дагуу арилжааны шимтгэлийн хувь өөрчлөгдсөн тухай мэдээлэл,
- Тендер, худалдан авалттай холбоотой 4 удаагийн 55.0 сая төгрөг
- Байгууллагын батлагдсан орон тоог шинэчлэн тогтоосон тухай мэдээлэл
- Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 27 удаагийн шийдвэрээр зарцуулсан 127.0 сая төгрөгийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан тус тус мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны 6 дугаар сарын 27-ний өдрийн 179 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн дараах зөвлөмжийг биелүүлээгүй байна. Үүнд:

1. Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн 334.1 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй ажиллах,
2. 2015 онд үүссэн ажилчдаас авах 1.2 сая төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэх,

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хөрөнгөтэй холбоотой асуудал :

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд эд хариуцагч нь кассын болон бараа материалын тайланг батлагдсан маягт зааврын дагуу бэлтгээгүй, нягтлан бодогч анхан шатны баримтанд үндэслэн санхүүгийн программд оруулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хөрөнгө дутагдах, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Санхүү эдийн засгийн сайд /хуучнаар/, Үндэсний Статистикийн Газрын даргын 2002 оны 171/111 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж

САГ-2019/171/СТА-ТӨҮГ

ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын дагуу кассын тайлан гаргаж сар бүр үлдэгдлийг тоолж баталгаажуулж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.2.Өглөгтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

2017 онд "Өмгөөллийн заяа энд золоо" компанитай хууль зүйн туслалцаа авах, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиглэээр гэрээ байгуулж төлбөрийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэж төлбөрийн үлдэгдэл 5.0 сая төгрөгийн өглөгийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө.” заасантай нийцээгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Тайлант жилийн зардал өсч үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төлбөр тооцоог тооцооны дансаар дамжуулан гүйцэтгэж байх, зардлыг зөв хуримтлуулан бүртгэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу , тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Зардалтай холбоотой асуудал:

3.3.1 Илрүүлэлт:

Сахилгын шийтгэлтэй албан хаагчдын цалингаас суутгал хийхдээ цалингийн зардлыг 2.5 сая төгрөгөөр бууруулсан нь Сангийн сайдын 2000 оны 116 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж,байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-ын 9 дүгээр зүйлийн 9.4.1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Цалингийн зардал бодитоор илэрхийлэгдэхгүйгээс гадна ажилтнуудын орлогын хэмжээнд нөлөөлөх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Сахилгын шийтгэлийн болон бусад суутгалын тооцооллыг зөв хийж, бүртгэлийг стандартын дагуу хөтлөх .

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу , тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

2017 онд Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын дагуу холбогдох өөрчлөлтийг тусгаагүй, НББОУС-2, НББОУС-16-д заасан тодорхойлолттой нийцээгүй, дансны нэгдсэн төлөвлөгөө нь програмын дансны кодчлолоос зөрүүтэй байгаа зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т *“Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Холбогдох стандарт, журмыг зөрчснөөс нягтлан бодох бүртгэлийг буруу хөтлөх, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох журам, зааврын дагуу өөрчлөлтийг тусган шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа:

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/01/2018	12/31/2018
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,006,323,183.53	1,125,858,816.57
1.1.2	Дансны авлага	291,250,192.74	586,852,835.20
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	52,442,974.42	66,956,897.65
1.1.4	Бусад авлага	8,551,920.73	3,310,180.26
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	20,924,457.75	31,932,624.55
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	377,416,085.27	54,274,908.67
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,756,908,814.44	1,869,186,262.90
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	206,453,417.94	172,501,986.99
1.2.2	Биет бус хөрөнгө	136,588,761.53	117,460,269.57
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	343,042,179.47	289,962,256.56

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,099,950,993.91	2,161,974,745.46
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	17,783,762.80	
2.1.1.2	Цалингийн өглөг	22,954.63	22,447.88
2.1.1.3	Татварын өр	185,756.04	147,968,945.64
2.1.1.4	НДШ–ийн өглөг	22,543.33	21,813.06
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	77,980,000.00	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,265,753.42	
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,002,700.45	462,700.45
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12	Бусад өр төлбөр	1,129,650,000.00	5,400,000.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,227,913,470.67	153,875,907.03
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	4,479,402.91	4,479,402.91
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5	Болзошгүй өр төлбөр	20,000,000.00	
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	24,479,402.91	4,479,402.91
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,252,392,873.58	158,355,309.94
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	1,021,700,000.00	1,021,700,000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	10,000.00	10,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(174,151,879.67)	981,909,435.52
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	847,558,120.33	2,003,619,435.52
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,099,950,993.91	2,161,974,745.46

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа:

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,867,167,114.06	2,330,075,894.84
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	1,867,167,114.06	2,330,075,894.84
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	55,080,328.72	131,902,845.18
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		579,147,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	5,305,071.46	13,642,818.18
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,428,248,662.33	1,306,696,282.76
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	1,973,192.49	373,029,198.92
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(111,662.47)	(121,332.24)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	486,608,854.03	1,347,636,107.92
19	Орлогын татварын зардал	50,399,879.81	147,953,895.31
20	Татварын дараах ашиг (алдагдал)	436,208,974.22	1,199,682,212.61
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	436,208,974.22	1,199,682,212.61
23	Бусад дэлгэрэнгүй орлого		

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	436,208,974.22	1,199,682,212.61
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа:

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриятлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	-	-	-	-	10,000.00	(610,360,853.89)	411,349,146.11
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл	1,021,700,000.00	-	-	-	-	10,000.00	(610,360,853.89)	411,349,146.11
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							436,208,974.22	436,208,974.22
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	-	-	-	-	10,000.00	(174,151,879.67)	847,558,120.33
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11	Залруулсан үлдэгдэл								
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							1,199,682,212.61	1,199,682,212.61
13	Бусад дэлгэрэнгүй орлого								-
14	Өмчид гарсан өөрчлөлт								-
15	Зарласан ногдол ашиг							(43,620,897.42)	(43,620,897.42)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,021,700,000.00					10,000.00	981,909,435.52	2,003,619,435.52

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа:

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	218,800,051,967.94	239,202,148,345.43
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,644,522,575.14	2,093,226,582.32
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	217,155,529,392.80	237,108,921,763.11
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	218,459,822,717.46	238,506,730,987.19
1.2.1	Ажиллагчдад төлсөн	844,661,288.37	567,249,830.48
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	269,612,313.06	178,432,658.15
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	62,150,144.11	52,193,535.29
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		107,537,636.40
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,619,949.98	7,078,660.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		69,934,294.78
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	217,263,779,021.94	237,524,304,372.09
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	340,229,250.48	695,417,358.24
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	54,977,705.23	129,076,619.18
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	54,977,705.23	129,076,619.18
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,820,356.37	38,107,446.96
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,820,356.37	38,107,446.96
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	50,157,348.86	90,969,172.22
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	142,461,662.47	666,850,897.42
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		121,600,897.42
3.2.5	Хувьцааны мөнгөний буцаалт	142,461,662.47	545,250,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(142,461,662.47)	(666,850,897.42)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	247,924,936.87	119,535,633.04
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	758,398,246.66	1,006,323,183.53
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,006,323,183.53	1,125,858,816.57

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	2019-03-14	Аудитын нэр	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
Шалгалдсан байгууллагын нэр:	Хөдөө аж ахуйн бирж ХХК			САГ-2019/171/СТА-ТӨҮГ
				Сая төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
3	Өглөг		2017 онд "Өмгөөллийн заяа энд золоо" компанитай хууль зүйн туслалцаа авах, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиглэээр гэрээ байгуулж төлбөрийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэж төлбөрийн үлдэгдэл 5.0 сая төгрөгийг өглөгийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.	5.0	Зөвлөмж	2019.03.14.		Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Х.Баатар Д.Батцэцэг
4	Зардал		Сахилгын шийтгэлтэй албан хаагчдын цалингаас суутгал хийхдээ цалингийн зардлыг 2.5 сая төгрөгөөр бууруулсан байна.	2.5	Зөвлөмж	2019.03.14.		Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Х.Баатар Д.Батцэцэг
5	НББ бодлогын баримт бичиг		2017 онд Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын дагуу холбогдох өөрчлөлтийг тусгаагүй, НББОУС-2, НББОУС-16-д заасан тодорхойлолттой нийцээгүй, дансны нэгдсэн төлөвлөгөө нь програмын дансны кодчлолоос зөрүүтэй байна.		Зөвлөмж	2019.03.14.		Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Х.Баатар Д.Батцэцэг
	Нийт дүн			7.5					